

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

№ 25/05

Улаанбаатар хот

**Хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг
нэмэгдүүлэх саналыг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.13 болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 24-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан эчнээ санал хураалтын үр дүн, Тооллогын комиссын тайланг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг дараах нөхцөл бүхий хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх саналыг баталсугай.

Гэрээ байгуулах тал	“АНД Системс” ХХК
Хоёрдогч өглөгийн нийт хэмжээ	3 (гурав) сая ам.доллартай тэнцэх төгрөг (ам.долларыг гэрээ байгуулах өдрийн Монголбанкны ханшаар хөрвүүлэн тооцно)
Хугацаа	5 (тав) жил
Хүүгийн төлбөр төлөх хугацаа	6 (зургаа) сар тутам
Эргэн төлөх нөхцөл	Хоёрдогч өглөгийн үндсэн өрийг Компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, компани татан буугдсан, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулснаас бусад тохиолдолд хугацаанаас өмнө эргэн төлөхгүй.
Хувьцаанд хөрвөх нөхцөл	Хугацааны эцэст ЛэндМН-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус хоёрдогч өглөгийг компанийн хувьцаанд хөрвүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Хэрвээ шилжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд шилжүүлэх нөхцөлийг тогтооно. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хоёрдогч өглөгийг Компанийн хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэснээс бусад тохиолдолд хугацааны эцэст эргэн төлнө.

2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан нөхцөлийн дагуу Хоёрдогч өглөгийн хүүг тогтоож, гэрээ байгуулах болон эдгээртэй холбогдон үүсэх бусад асуудлаар холбогдох хууль, тогтоомжийн дагуу Хувьцаа эзэмшигчийн хурлын хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
3. Энэхүү шийдвэртэй холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хороонд холбогдох мэдэгдэл хүргүүлж, зөвшөөрөл хүсэх, шаардлагатай баримт бичгийг баталгаажуулах, бүрдүүлж өгөх,

эдгээртэй холбоотой бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

4. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад даалгасугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

№ 25/06

Улаанбаатар хот

**Компанийн дүрэмд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4.1, 8.5.1 дэх заалт болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 24-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан эчнээ санал хураалтын үр дүн, Тооллогын комиссын тайланг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.

1.1 Компанийн салбар, төлөөлөгчийн газрын оршин байрлах хаяг өөрчлөгдөж буйтай холбогдуулан Компанийн дүрмийн 2.2 дахь заалтад дараах өөрчлөлтийг оруулах:

*“Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь дараах хаягт оршин байрлана:
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34 хаягт байрлах
Сүвд төв, 1 тоот” гэж заасныг,*

*“Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь дараах хаягт оршин байрлана:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол /14252/ Сөүлийн
гудамж 13А, “Алтан Жолоо Тауэр” оффис, 1 дүгээр давхар, 02 тоот” гэж өөрчлөх;*

1.2 Компанийн дүрэмд дараах агуулгатай 24 дүгээр зүйл нэмэх;

“24. Ахмадын сан

24.1. Компани нь Монгол Улсын Ахмад настны тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд заасан зорилгын хүрээнд захиран зарцуулахаар Ахмадын санг байгуулж, түүнд төвлөрүүлэх үнийн дүнг жил бүрийн төсөвт тусгана.

24.2. Компанийн ТУЗ-өөс Ахмадын санд төвлөрүүлэх үнийн дүнг Компанийн тухайн жилийн төсөвт тусгасан цалингийн нийт сангийн 3 (гурав) хүртэлх хувь байхаар тогтооно.

24.3. Компани нь Ахмадын санг байгуулах, мөнгөн хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтоох, бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах зэрэг харилцааг холбогдох дотоод журмаар зохицуулна.”

1.3 Энэхүү тогтоолын 1.1 болон 1.2-т заасан Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Компанийн дүрмийн 24 дүгээр зүйлийг 25 дугаар зүйл, 25 дугаар зүйлийг 26 дугаар зүйл болгож тус тус дугаарлалтыг өөрчлөх.

2. Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт зааснаар Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг энэхүү шийдвэрийн Хавсралтаар дүрэмд тусган баталсугай.

3. Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн салбар, төлөөлөгчийн газрын албан ёсны хаяг өөрчлөхтэй холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооноос холбогдох зөвшөөрөл хүсэх, шаардлагатай баримт бичгийг баталгаажуулах, бүрдүүлж өгөх, эдгээртэй холбоотой бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх болон Ахмадын санг байгуулах, захиран

зарцуулах, тайлагнах зэрэг харилцааг холбогдох дотоод журмаар зохицуулах бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

4. Энэхүү шийдвэрийн Хавсралтаар батлагдсан Компанийн дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, тийнхүү бүртгүүлэхтэй холбоотой аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Компанийн Хууль, хянан нийцүүлэлтийн мэргэжилтэн (Х.Хулан /РД: , М.Маралмаа /РД: нарт үүрэг болгосугай.
5. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, шийдвэрийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан шаардлагатай шийдвэр, тогтоол гаргаж, мөрдүүлэн ажиллахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

